

“Авлигатай тэмцэж шударга ёсыг тогтоон бэхжүүлэх нь”

ШУТИС-Нийгмийн Технологийн Сургууль

# ИЛТГЭЛ

**Сэдэв:** “Авлигатай тэмцэх нийгмийн ажилтны **3D** технологи”

**Илтгэгч:** Н.Цэрэндаваа ШУТИС-НТС НА-4 |курс|

Улаанбаатар хот

2011он

“Авлигатай тэмцэж шударга ёсыг тогтоон бэхжүүлэх нь”

## Агуулга

1. Үндэслэл
2. Судлагдсан байдал
3. Илтгэлийн зорилго
4. Илтгэлийн зорилт
5. Илтгэлийн шинэлэг тал
6. Судалгааны ажил
7. Өнөөгийн нөхцөл байдал
8. Өөрчлөлтийг хийх арга зам
  - ✚ Авлигатай тэмцэх газар болон авлигатай тэмцэх газрын албан хаагч
  - ✚ Нийгмийн ажил мэргэжил болон нийгмийн ажлын үйлчилгээ
  - ✚ “3D” технологийн тухай
  - ✚ Авлигатай тэмцэх нийгмийн ажилтны цогц үйлчилгээний “3D” технологийн тухай
9. Ирээдүйн чиг хандлага
10. Дүгнэлт
11. Санал зөвлөмж
12. Ном зүй

“Авлигатай тэмцэж шударга ёсыг тогтоон бэхжүүлэх нь”

**Үндэслэл**

Авлига гэж далд, давтагддаг, даамжирдаг мөсөн уул юм. Мөсөн уул бол 90% нь далд 10-н хувь ил и байдаг байна. Үүнтэй адилаар монголын нийгэмд авлигал ил болон далд байдлаар оршин буйг бид нээн илрүүлж таслан зогсоох арга хэмжээг авах зайлшгүй шаардлага байна. Судалгаанаас үзэхэд:

“Авлигалтай тэмцэх үндэсний хөтөлбөр” - ийн хэрэгжилт, авлигалтай тэмцэх талаарх олон нийтийн санал бодол  
/мониторингийн 2004 оны судалгааны тайлангаас/

*Өнөөгийн Монголд авилгал хэр зэрэг газар авсан вэ? /1999 оны санал асуулгатай харьцуулсан байдлаар/*

	1999 он	2004 он
<i>маш их дэлгэрсэн</i>	<b>48.8</b>	<b>35.7</b>
<i>ер нь дэлгэрсэн</i>	<b>44.2</b>	<b>53.2</b>
<i>тийм их биш ба дэлгэрээгүй</i>	4.4	4.3
<i>мэдэхгүй+хариулаагүй</i>	2.6	6.8

Судалгаанд оролцогчдын дийлэнхи олонхи нь /88.9 хувь/ Монголд авилгал дэлгэрсэн хэмээн хариулжээ. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцогчид нь нас, хүйс, боловсрол, намын харъяалал, оршин суух газар зэрэг нийгэм-хүн ам зүйн үзүүлэлтээсээ үл хамаарч нийтээрээ Монголд авлигал нийгмийн бодит үзэгдэл болж хувирсан гэж үзсэн байна.

“Авлигал хот хөдөө аль ч газар байдаг зүйл, хотод их хөдөөд бага гэж ойлгож болохгүй, бүх шатанд байгаа зүйл, авлигалд автаагүй газар орон нутаг, байгууллага гэж өнөөдөр байхгүй, шат шатандаа авлигалд автсан”

... Дорнод аймгийн холимог бүлгийн ярилцлагаас ...

## “Авлигатай тэмцэж шударга ёсыг тогтоон бэхжүүлэх нь”

“Авлигал өнөөдөр хавтгайрч нэлэнхүй болсон гэж боддог, хаана ч очоод ямар нэг ажил бүтээхэд нэг бол танил талаа бараадах, нэг бол гар цайлгаж, шан харамж өгөх болдог.”

... Улаанбаатар хотын Нарантуул захын наймаачдын бүлгийн ярилцлагаас

Санал асуулгад хамрагсдын дийлэнх олонхи буюу 66.1 хувь нь авлигалын илрүүлэх асуудал манай улсад хангалтгүй байна гэж үзсэн байна. 1999 оны санал асуулгын дүнтэй харьцуулахад олон нийтийн санал бодол тархалтын хэлбэрийн хувьд төдийлөн өөрчлөгдөөгүй боловч хувийн жингийн хувьд “хангалтгүй” гэсэн үнэлгээ мэдэгдэхүйц өссөн байна.

1996 онд Авлигалын эсрэг хууль, мөн 2002 онд авлигалтай тэмцэх үндэсний хөтөлбөрөө батлан гарсан явдал нь авлигалын эсрэг тэмцэх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой баримт бичгүүд болсон юм. Энэхүү хууль болон үндэсний хөтөлбөр батлагдаад нэлээд хугацаа өнгөрсөн ч өнөөг хүртэл түүний хэрэгжилт нь нийгэмд тодорхой бус, хангалтгүй, нааштай үр дүнд хүрч чадаагүй гэдгийг судалгааны дүн нотолж байна.

Авлигалын тархалтын талаарх олон нийтийн мэдрэмж, авлигалтай тэмцэх тэмцэлд олон нийтийн хүлээлт онцгой байр эзлэж байгаа бөгөөд манай судалгаанд хамрагсдын ердөө л 3.8 хувь нь ойрын нэг хоёр жилд багасна, 33.9 хувь нь энэ хэвээрээ байна, харин **38.1** хувь нь нэмэгдэнэ, 24.2 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

### “МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ” 2010 оны СУДАЛГААНЫ ТАЙЛАНГААС

Авлигалтай тэмцэхэд байгууллагын үүрэг /давхардсан тоогоор/

<b>Иргэд олон нийтийг татан оруулах</b>	<b>59.2</b>
авлигалд өртсөнд хяналт	54.4
сургалт сурталчилгаа	46.0
Холбогдох байгууллагаас шаардагдах	40.0
Авлигалтай тэмцэхэд туслах	31.2

## “Авлигатай тэмцэж шударга ёсыг тогтоон бэхжүүлэх нь”

Холбогдох байгуулагуудадад мэдээлэх	25.6
Гадаадын ТББ- тай хамтран ажиллах	15.2
Бусад	2.5

Иргэд, үйлчлүүлэгчид төрийн байгууллагаас төрийн үйлчилгээг шударгаар үзүүлэхэд албан хаагчдын мэдлэг ур чадвар, түргэн шуурхай байдал, соёлтой боловсон үйлчлэх, ёс зүйтэй байх, хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй тэгш хандаж үйлчлэх нь илүү чухал ач холбогдолтой гэж үзсэн байна.

Эдгээр статистик болон өөрийн судалж мэдсэн зүйлээрээ авлигалыг таслан зогсоох 3D технологийн үндэслэл дэвшүүлж байна.

### **Судлагдсан байдал**

Авлигатай тэмцэх, авлигыг таслан зогсоох арга замыг олон судлаач эрдэмтэн сонирхогчид тодорхойлон гаргаж өөр өөрсдийнхөөрөө тайлбар хийсэн байдаг ч авлигатай тэмцэхэд нийгмийн ажилтны үүрэг, оролцоо, арга технологийг судлан шинжилж санал дэвшүүлсэн тохиолдол байхгүй юм.

### **Илтгэлийн зорилго**

Авлигатай тэмцэхэд мэргэжлийн нийгмийн ажилтны үүрэг оролцоо шаардлагатайг олон нийтэд ойлгуулан таниулах, авлигатай тэмцэх нийгмийн ажилтны цогц үйлчилгээний шинэ технологийг судлан тодорхойлоход оршино.

### **Зорилт**

- ✚ Авлигалын эсрэг НҮБ-ын Конвенцийг судлан танилцах
- ✚ Монгол улсын хууль, авлигын эсрэг хууль болон бусад хууль тогтоомжуудыг уншиж танилцах, судлах

“Авлигатай тэмцэж шударга ёсыг тогтоон бэхжүүлэх нь”

- ✚ Судалгааны мэдээлэл цуглуулж мэдээлэлд дүн шинжилгээ хийх аргачлал боловсруулах
- ✚ Авлигатай тэмцэх байгууллага ажилтны талаар судлах, танилцах
- ✚ Нийгмийн ажлын боловсролын стандартыг уншиж мэдлэгээ сэргээн санах
- ✚ 3D технологийн талаар судлах мэдлэгээ дээшлүүлэх
- ✚ Нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээг 3D технологитой уялдуулан хоорондын уялдаа холбоо шүтэлцээ хамаарлыг нь тодорхойлох
- ✚ Нийгмийн ажлын үйлчилгээний шинэ технологийг тодорхойлох
- ✚ Дүгнэлт гаргаж санал зөвлөмж болосруулах

#### **Илтгэлийн шинэлэг тал**

Авлигатай тэмцэхэд нийгмийн ажилтны гүйцэтгэх үүрэг, оролцоо, нийгмийн ажлын цогц үйлчилгээний шинэ технологийг авлигалтай тэмцэхэд зориулан боловсруулсанд оршино.

#### **Судалгааны ажил**

Чанарын судалгааны ганцаарчилсан ярилцлагын аргаар 45 хүнээс бичил судалгааг авсан. Ярилцлагандаа GOP загварыг ашигласан юм. Судаалгаанаас хамгийн нийтлэг хариултуудыг авч тайланд оруулав.

#### **Авлигалын өнөөгийн байдал, хүндрэлтэй асуудлууд.....,**

**Төрийн албаны бүх шатанд гар хардаг авлигалын үүр уурхай болсон.**

**Олон нийт нийгэм тэр чигээрээ бүгд л авлига байх ёстой хэнч үүнийг таслан зогсоож чадахгүй гэж үзэж байгаа.**

**Гаалийн байгуулгын ажилтнууд хамгийн их авлигал авдаг болсон нь улс орны аюулгүй байдалд аюул авчрах томоохон эрсдэл юм.**

**Эмч нар гар хардаг хахуул авах гээд хүний амь нас аврах ёстой байтал хөсөр хаядаг энэ бол ёс зүйгүй зүйл юм.**

“Авлигатай тэмцэж шударга ёсыг тогтоон бэхжүүлэх нь”

Сургууль цэцэрлэг гээд боловсролын байгуулгууд авлигын үүр болсон нь үнэнхүү хүндрэл чирэгдэл авчирч байна.
Нийгэм тэр чигээрээ бүгд авлигад автаагүй ч шударга зарим нэгийг нь амьдралын шаардлага авлигалч болгодог.
Төрийн өндөрлөгт байгаа томчууд эрх мэдэлтнүүд л энэ бүх авлигалын эхлэл болж байгаа.
Албан тушаал дэвшихийн тулд л хүмүүс хахуул өгдөг авдаг тогтолцоо бий болсон.
Авлигалын сүлжээ нийгмийн бүх давхрагад байсаар байгаа.
Нийгмийн амьдрал ядуу тарчиг материаллаг зүйлсийг шүтэгч байгаа нь авлигалд нөлөөлдөг.
Эрх мэдлийн төлөөх тэмцэлд хамгийн чухал нь авлигал болсон.
Хамаатан садан танил талаараа ажил амжуулдаг эд бүгд мөн л авлигалын нэгэн хэсэг болж байгаа юм.
Бизнесийн салбарт амжилттай ажиллаж амьдрах нөхцөлийг авлигаар л бүрдүүлнэ.
Хүүхэд багачууддаа буруу үлгэр дуурайл болдгоос удам залгасан авлигалчдыг бид өөрсдөө л бэлдэж байна.
Шударга үнэнч хүмүүс нийгэмд байгаа ганцхан тэднийг олоход бэрхшээл их тулгарна учир нь гэвэл хүмүүсийн олонхи нь авлигал өгдөг авдаг болсон.
<b><i>Хэтийн зорилго, ирээдүйд ямар байвал зохих вэ?</i></b>
Нийгэм олон нийт шударга ёсыг үнэт зүйлээ болгодог,улс төрчид нь эх орны хөгжлийг эрхэм болгон шударгаар хөдөлмөрлөх, эмч багш нар нь хүний төлөө ажиллаж ёс зүйтэй амьдрах иргэд аж ахуй нэгж байгууллагууд нь шаардлага хяналт өндөр байж хүүхэд багачууддаа зөв үлгэр дуурайлтай сайн сайхан нийгэм байгаасай хэмээн хүс ч байна.
<b><i>Яаж ямар арга замаар өөрчилж болох вэ?</i></b>
Төрийн албан хаагчид шударга ёсыг эрхэмлэдэг болгоход авлигалын эсрэг тэмцэгчдийн өөрсдийн мэдлэг чадвар үнэнч шударга байдал маш чухал.
Иргэд аж ахуйн нэгж байгууллага гээд бүх нийгэм нийтээрээ тэмцэж байж л авлигалыг таслан зогсоож чадна.

“Авлигатай тэмцэж шударга ёсыг тогтоон бэхжүүлэх нь”

<p>Улсын хил гаалиар бараа бүтээгдэхүүнийг шалгаж оруулах чухал хариуцлагатай ажил хийдэг ажилтнууд шударга харилцааны соёлтой болж нийгмийн хөгжилд хөтөлнө.</p>
<p>Авлигалаас урьдчилан сэргийлэх ажил сайн байвал аажимдаа шударга ёс тогтоно.</p>
<p>Хүүхэд багачууд бага наснаасаа зөв ухамсар хүмүүжилтэй шударга ёсыг эрхэмлэдэг болох юм бол авлигалын үргэлжлэлийг таслан зогсоож чадна.</p>
<p>Авлигатай тэмцэх байгууллага нь үйл ажиллагааны чанар хүрмээмж өндөртэй ажилтан албан хаагчид хариуцлага ёс зүйг сахин биелүүлдэг байж л тэмцэж өөрчилж чадна.</p>
<p>Улс төрчдийн ил тод үйл ажиллагаа шударга байдал маш чухал тэдний авлигалыг илрүүлэн шийтгэж чадвал нийгэм дэхь авлигал багасна.</p>
<p>Албан тушаалын өсөлтийг авлигалын өсөлт бус мэдлэг чадвар туршлагын өсөлт болгож чадвал шударга ёс бий болно.</p>
<p>Хүмүүсийн ухамсар сэтгэлийн гүнд байгаа сөрөг бодлыг шунах сэтгэлийг арилгаж чадвал авлигал арилна.</p>
<p>Авлигатай тэмцэх байгууллагын ажилтнууд хэний ч нөлөөнд автагдахааргүй ар гэр нийгмийн асуудлаа шийдвэрлэсэн байх шаардлагатай.</p>
<p>Эрх мэдэлтнүүдийн дунд албан тушаал томилолтод нөлөөлөх албан бус нөлөөллийг бууруулах хэрэгтэй.</p>
<p>Нэг албан байгууллагад олон хамаатан садан төрөл ажилдаг үүнийг болиулах ёстой, авлигатай тэмцэх газрын цэвэрлэгч нь хүртэл шударга үнэний төлөө тэмцэгч байх ёстой.</p>
<p>Төрийн албан хаагчдыг бизнес эрхлэгчдээс хараат бус тэдний нөлөөнд автахааргүй нөхцлийг бүрдүүлэх хэрэгтэй.</p>
<p>Төрийн гэлтгүй төрийн бус байгууллагуудад авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаа хүрэх шаардлага байгаа тэгж л нийгэм бүхэлдээ өөрчлөгдөх болно.</p>



“Авлигатай тэмцэж шударга ёсыг тогтоон бэхжүүлэх нь”

**Нийгэмд авлигалын эсрэг тэмцэгч хувь хүн бүлэг олон нийт байгууллага олон байгаа тэдний хүчийг авлигатай тэмцэх газар ашиглан хамтран ажиллах шаардлагатай ингэж нийгэм тэр чигээрээ бүгд хамтдаа тэмцэж чадвал авлигалыг таслан зогсоож чадна.**

### **Өнөөгийн нөхцөл байдал**

Монгол улсын төрийн болон төрийн бус байгуулгын ажилтан албан хаагчид, эрх мэдэлтнүүд бүгд л авлигал хэмээх энэ шударга ёс дайсанд дурлах болжээ. Эмч нар нь хүний амь наснаас илүү мөнгөнд хайртай, эрх мэдэлтнүүд нь эх орноосоо илүү эд баялагт дурладаг, дунд түвшний ажилтнууд нь албан тушаалын төлөө ажил үүргээ умартан зүтгэдэг, энгийн иргэд нь ажил амьдралын шаардлагаар авлигал өгдөг, өгч байж л өөрийн эрх ашгийг хамгаалдаг, хүүхэд багачууд нь авлигалаар баяжсан хөрөнгөтнөөс үлгэр дуурайл авдаг ийм л нөхцөлд монголчууд бид амьдарч байна гэсэн хэдий хүн бүрийн дотор энэ бүхэн өөрчлөгдөнө гэсэн итгэл байна.

### **Өөрчлөлтийг хийх арга зам**

**Авлигатай тэмцэх газар болон авлигатай тэмцэх газрын албан хаагч нь:**

15.1 Авлигатай тэмцэх газар нь авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, энэ хуульд заасан этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан, төрийн тусгай байгууллага мөн. | авлигын эсрэг хууль |

19.1 Авлигатай тэмцэх газрын албан хаагч нь ял шийтгүүлж байгаагүй, төрийн байгууллагад ажиллаж байхдаа ёс зүйн дүрэм зөрчиж, сахилгын шийтгэл хүлээж байгаагүй, дээд боловсролын бакалавраас доошгүй зэрэгтэй, тухайн ажлын талаар мэдлэг, ур чадварын шаардлага хангасан Монгол Улсын иргэн байна. | авлигын эсрэг хууль |

“Авлигатай тэмцэж шударга ёсыг тогтоон бэхжүүлэх нь”

### Нийгмийн ажил мэргэжил болон нийгмийн ажлын үйлчилгээ нь:

- “Нийгмийн ажил” нь нийгмийн өөрчлөлтийг дэмжиж, хүмүүсийн харилцаан дахь бэрхшээлтэй асуудлыг **шийдвэрлэх**, хүмүүсийн сайн сайхны төлөө тэднийг **чадваржуулж, эрх чөлөө боломжийг** нь өргөжүүлэхэд туслах мэргэжлийн үйл ажиллагаа юм. | нийгмийн ажил мэргэжлийн боловсролын стандарт |
- “Нийгмийн ажлын үйлчилгээ” гэдэг нь нийгэм болон хүмүүсийн хүмүүсийн сайн сайхны төлөө нөөц боломжийг илрүүлэх, хөгжүүлэх, **урьдчилан сэргийлэх**, нөхөн сэргээх, хамгаалах зорилгоор үзүүлж буй мэргэжлийн үйл ажиллагааны цогц юм. | нийгмийн ажил мэргэжлийн боловсролын стандарт |
- Авлигатай тэмцэх нийгмийн ажилтан авлигалчийг өөрчлөхүү? Орчныг нь өөрчлөх үү? Хоёуланг нь өөрчлөх үү? Гэсэн сонголтоос хоёуланг нь өөрчлөх сонголт хийх зайлшгүй шаардлагатай.

### “3D” технологи нь:

Гурван хэмжээст **нүдэнд харагдаж, гарт баригдах, чихэнд сонсогдох, сэтгэлд мэдрэгдэх** бодитой мэт мэдрэмжийг төрүүлдэг бөгөөд аливаа зүйлийг бүх талаас нь **дуу, дүрс, өнгө**ний өндөр ялгаралтайгаар бодитоор харах боломжийг олгодог.

### Авлигатай тэмцэх нийгмийн ажилтны цогц үйлчилгээний “3D” технологи нь:

- ✚ Авлигалийг **өнгөрсөн одоо ирээдүй** 3 цагийн хэлхээнд авч үздэг.
- ✚ Авлигалаас **урьдчилан сэргийлэх**, авлигалд өртөхөөс **хамгаалах**, авлигачдад **нөлөөлөх** үйлчилгээ үйл ажиллагаа зохион байгуулдаг.
- ✚ **микро, мезо, макро** түвшиний нийгмийн ажлын үйлчилгээг харилцан уялдаатай хүргэдэг
- ✚ Хүний давуу тал, нөөц боломжийг **судлан шинжилж, дэмжин хөгжүүлж, хадгалан хамгаалдаг.**

## “Авлигатай тэмцэж шударга ёсыг тогтоон бэхжүүлэх нь”

- ✚ Мэдлэгтэй, мэдрэмжтэй, мэргэжлийн итгэл үнэмшилтэй |**ЗМ**| нийгмийн ажилтан мэргэжилтэнтэй
- ✚ **ЗД** /далд,давтагддаг,даамжирдаг/ - авлигалтай **ЗД** авлигатай тэмцэх технологиор ажилдаг хувь хүн бүлэг хамт олонтой **хамтран ажиллах**
- ✚ Авлигатай тэмцэх үйл ажиллагааг монголын ард түмний:
  - Нүдэнд нь харагдтал
  - Чихэнд нь сонсогдтол
  - Гарт нь баригдтал
  - Сэтгэлд нь хоногштол
  - Амьдралд нь мэдрэгдтэл

Зохион байгуулдаг идэвхи санаачлагатай, хийж бүтээдэг, шударга ёсыг эрхэмлэдэг, багаар ажиллах чадвартай, итгэлтэй, найдвартай, баталгаатай **орчин үеийн мэргэжилтнүүдээс** бүрдсэн атгасан шагай шиг хамт олон байгууллага байх

- ✚ Эрүүл чийрэг бие бялдартай, саруул уужим оюун ухаантай, цэвэр ариун ёс суртахуунтай, элбэг хангалуун амьдралтай хүн нь цогц чадамжийн нэгдмэл тогтолцоо. | **орчин үеийн мэргэжилтэн** |

Эцсийн дүндээ энэ бүхнийг цогцлоон хөгжүүлсэн байгууллага бол авлигатай тэмцэх **ЗД** үйл ажиллагааны технологитой байх бөгөөд *үр дүн, үр өгөөж, үр шим* нь мөн адил **ЗД** байх юм.

### Ирээдүйн чиг хандлага

- Халамжийн нийгмийн ажилтнаас хөгжлийн нийгмийн ажилтан | Авлигатай тэмцэх НА |
- Ганцаарчилж ажиллах - Багаар ажиллах – Хамтарсан багаар ажиллах
- Нэг хүн нэг байгууллагын тэмцлээс нийт нийгэм хамт олноороо авлигатай тэмцэх

## “Авлигатай тэмцэж шударга ёсыг тогтоон бэхжүүлэх нь”

- Хүний бие, оюунтай ажилдаг арга барилаас хүний сэтгэл хүний мөн чанар хүмүүжилтэй ажилладаг арга барил
- Тооны өсөлт - чанарын өсөлт - үр дүн, үр шим, үр өгөөж, үр ашиг
- Хамаатан садан танил талаараа ажилд орох бус мэдлэг чадвар хүсэл тэмүүлэл чин сэтгэлээрээ амжилтанд хүрэх
- Хянаж шалгах ажиллагаанаас урьдчилан сэргийлэх нөлөөлөх ажил үйлчилгээнд шилжих

### Дүгнэлт

- ❖ Авлигатай тэмцэхэд иргэн бүрийн оролцоо чухал бөгөөд иргэн бүр авлига өгдөггүй авдаггүй өгсөнийг нь мэдээлдэг авсаныг нь мэдээлдэг үр хүүддээ зааж зөвлөдөг байх шаардлагатай юм.
- ❖ Авлигатай тэмцэх байгууллагын ажилтнууд нь нэгэн атгасан шагай мэт цул баг байж энэ байгууллагын үйл ажиллагаа үр дүнтэй хүрэх болно. Энэ байгууллагад ажиллах дарга удирдлагаас авхуулаад энгийн үйлчлэгч цэвэрлэгч нь хүртэл шударга ёсыг эрхэмлэдэг байх шаардлагатай байна.
- ❖ Авлигатай тэмцэх үйл ажиллагааны хамгийн гол нь анхаарал хандуулах шаардлагатай ажил бол авлигалаас урьдчилан сэргийлэх ажил.
- ❖ Авлигатай тэмцдэг оюутан залуус хувь хүмүүс төрийн бус байгууллагатай нягт хамтран ажиллах нь авлигатай тэмцэх байгууллагын үйл ажиллагааны анхаарал хандуулах зүйлийн нэг юм.
- ❖ Авлигатай тэмцэх үйл ажиллагааг харилцан уялдаатайгаар судалгаа шинжилгээний ажилд тулгуурлан явуулах нь шинэчлэлт өөрчлөлт хийх эх үндэс болох юм.
- ❖ Авлигалыг таслан зогсооход хамгийн чухал үүрэг гүйцэтгэх хүмүүс бол төрийн албан хаагчид бөгөөд тэдний нийгмийн асуудлаа шийдвэрлэсэн байдал, ажил албандаа хандах хандлага, шударга ёсыг эрхэмлэх, ёс зүйтэй байдал зэргээс ихээхэн хамаарах юм.

## “Авлигатай тэмцэж шударга ёсыг тогтоон бэхжүүлэх нь”

### Санал зөвлөмж

- ✓ Авлигалын сүлжээний эсрэг тэмцэх хамтран ажиллагчидийн мэдээллийн сүлжээтэй тэмцэх
- ✓ Авлигатай тэмцэх нийгмийн ажилтны 3D технологийг хэрэгжүүлэхэд хамтран ажилах, үйл ажиллагаандаа ашиглах
- ✓ Авлигатай тэмцэхэд их дээд сургууль төгсөж буй шинэхэн оюутан залуусаар байгууллагын захиалгат диплом бичүүлэн ажилтнаар мэргэшүүлэн бэлтгэж нийгмийн асуудлыг тодорхой хэмжээгээр шийдэж өгөөд чин үнэнч сэтгэлээр авлигатай тэмцэх үйл ажиллагаанд хүч нөөцийг нь дайчлах
- ✓ Авлигалтай тэмцэх сайн дурын бүлэглэлийг дэмжиж хамтран ажиллах
- ✓ Хөрөнгө орлогын мэдүүлгийг илүү дэлгэрэнгүй он оны мэдээлэлтэй байдлаар авч жил бүр харьцуулах дүгнэх замаар ашиглах
- ✓ Төрийн албан хаагчдын албан тушаалын өсөлтөд албан бус харилцааны тандалт судалгааг хийж байх
- ✓ Авлигатай тэмцэх газар мэргэжлийн нийгмийн ажилтны орон тоотой болж судалгаа шинжилгээ, ажилчдын нийгэм сэтгэлзүйн асуудал, нөлөөллийн ажил, урьдчилан сэргийлэх ажил зэргийг сайжруулахад анхаарах хэрэгтэй юм.
- ✓ Хүний оюун ухаан, хүний мөн чанар, сэтгэл санаа, үзэл бодолд нь нөлөөлөх шинэ хандлагыг төлөвшүүлэхэд анхаарвал зохилтой юм.

### Ном зүй

- “Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр” - ийн хэрэгжилт, авилгалтай тэмцэх талаарх олон нийтийн санал бодол | мониторингийн 2004 оны судалгааны тайлан |
- “Монголын төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх” 2010 оны судалгааны тайлан
- Нийгмийн ажлын боловсролын стандарт
- [www.iaac.mn](http://www.iaac.mn) | Авлигын эсрэг хууль |